

Golomt Capital®

# БОНДЫН

---

ЗАХ ЗЭЭЛИЙН ДОЛОО  
ХОНОГИЙН ТОЙМ



2025.09.24



## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН БОНД

Нэр	Дуусах хугацаа	Купон	Өгөөж
Номад	2026.04.07	5.125%	5.34%
Монгол 27	2027.07.07	3.50%	5.55%
Хүннү	2028.01.19	8.65%	5.65%
Монгол 29	2029.06.05	7.875%	5.84%
Монгол 30	2030.02.25	6.625%	6.11%
Монгол 31	2031.07.07	4.45%	6.33%

Эх сурвалж: Bloomberg

Монгол Улсын Засгийн газар бондуудын өгөөж 5.34%-6.11% хооронд хэлбэлзэж байна.



## КОМПАНИЙН БОНД (АМ.ДОЛЛАР)

Нэр	Дуусах хугацаа	Купон	Өгөөж
Голомт Банк (GLMT)	2027.05.20	11.00%	8.13%
МИК (MIK)	2027.01.18	11.50%	11.78%
TDBM	2027.12.23	8.5%	8.72%
DBM	2026.03.07	11.00%	5.61%

Эх сурвалж: Bloomberg

Компанийн ам.долларын бондуудын өгөөж 5.61%-11.78%-ийн түвшинд хэлбэлзэж, эрсдэлийг давж өндөр өгөөж хайж буй хөрөнгө оруулагчдын сонирхлыг татаж байна. Голомт Банк олон улсын зах зээлд жилийн 11%-ийн хүүтэй, 2027.05.20-нд хаагдах 300 сая ам.долларын бондыг амжилттай гаргасан бөгөөд хоёрдогч зах зээлийн арилжаагаар худалдан авах боломжтой хэвээр байна.

Golomt Capital

2021-2024 он

**19%**

дундаж хүү

Нийт

**3.000**

хөрөнгө оруулагч

Нэг хөрөнгө оруулагч

**95 сая ₮**

хүртсэн өгөөж



Одоо

**₮20%**

БОНД АВАХ  
**₮10 сая**



жишээ

ХҮРТЭХ  
**₮2 сая**  
ӨГӨӨЖ

## AM.ДОЛЛАРЫН БОНДЫН СУУРЬ МЭДЭЭЛЛҮҮД

Ам.долларын бондод хөрөнгө оруулах алтан үе ирээд байна

График 1. 10 жилийн хугацаатай АНУ-ын ЗГ-ын өгөөж



TradingView

АНУ-ын Төв банк 9-р сарын 17-нд бодлогын хүүгээ 0.25 хувиар бууруулж, хүлээлтийн дагуу шийдвэрийг гаргалаа. Ингэснээр АНУ-ын 10 жилийн хугацаатай бондын өгөөж өслөө. Хүү буурснаар хуучин бондуудын эрэлт нэмэгдэж үнэ нь өсдөг зүйл ажиглагддаг. Мөн энэ ондоо багтаад дахин 2 удаа хүүг бууруулна гэсэн хүлээлт байгаа учраас үргэлжлэн бондын өгөөж таамаглалын дагуу буурах магадлал өндөр хэвээр байна. 10 жилийн хугацаатай бондын өгөөж 3.84% хүртэл буурах магадлал өндөр байна.

График 2. Ам.долларын индекс



TradingView

Ам.долларын индекс 99 түвшнээс эсэргүүцэл аван доош унаж байна. Бодлогын хүү буурч доллар зарах хүмүүс ихэсч байгаагаас гадна алтны ханш өдөр ирэх тусам нэмэгдэж байна. Үргэлжлэн долларын индекс 96.24 гэсэн түвшинг сэтлэн доош унах магадлалтай.



## ДОТООДЫН ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

## Анхдагч зах зээлээс авах боломжтой бондууд


№	Бондын нэр	Төрөл	Купон	Хүү төлөлт	Салбар	Хугацаа	Захиалга эхлэх хугацаа
1	БСБ Финанс Бонд	Хаалттай	19.00%	Улирал тутам	ББСБ	12 сар	10 сараас
2	Хан-алтай Бонд	Хаалттай	20.00%	Улирал тутам	Уул уурхай	24 сар	10 сараас
3	Бэрс Бонд	Нээлттэй	19.50%	Улирал тутам	ББСБ	24 сар	9 сарын сүүлээр

## Биржийн бус зах зээлийн бондын өгөөжийн муруй

Бондын өгөөжийн муруй нь зах зээлд гарч буй бондуудын хугацаа болон өгөөжийн хамаарлыг нь илтгэдэг. Өгөөжийн муруйг дараах зорилгоор ашиглах боломжтой. Үүнд:

- Үнэт цаасны өгөөжийн хувь үнэт цаасны хугацаанаас хамааран хэрхэн ялгаатай тогтож байгааг мэдэх
- Шинээр гаргах үнэт цаасны үнэ ханш, өгөөжийг тогтоох жишиг хувь болох
- Бусад бондын өгөөжтэй харьцуулан шийдвэр гаргах боломжийг олгодог юм.

График 2. Бондын өгөөжийн муруй (2024.10-р сард бодлогын хүү өөрчлөгдсөнөөс хойш)



**ЗГҮЦ-НЫ АРИЛЖАА  
3 ЖИЛИЙН ХУГАЦААТАЙ  
БОНД ЗАХИАЛГА  
АВЧ БАЙНА**

8083-7744 | 8665-4422 | 8665-1177